


1 Зурагт ямар төлөвтэй бодисыг шилэн аяганд хийсэн байна вэ?




- A хий
- B хатуу
- C шингэн
- D плазма

2 Тасалгаанд байгаа дараах бодисуудаас жижиг хэсгийг нь дээрх зургийн 1 дугаартай бодисын загвараар илэрхийлэх боломжтой бодисыг нэргэнэ үү?




- A цай
- B йогурт
- C хүчилтөрөгч
- D ширээ

3 Нэгэн бодис төлөвийн шилжилтэд орсон нь дээрх зургийн 2 дугаартайгаас 3 дугаартай руу шилжсэн гэж илэрхийлэгдэх бол энэ бодис ямар төлөвийн шилжилтэд орсон бэ?




- A хайлах
- B царцах
- C уурших
- D конденсацлах

4 Дээрх зурагт үзүүлсэн дугаарласан гурван бодисын алинд нь жижиг хэсэг нь хамгийн эмх цэгцтэй вэ?




- A 1
- B 2
- C 3
- D 1,3

5 Зурагт дугаарласан гурван бодисын жижиг хэсэг хоорондын зай ихсэх дараалалд оруулсан эгнээг сонгоорой.




- A 1→2→3
- B 3→2→1
- C 2→1→3
- D 3→1→2

6 Өөрийн гэсэн хэлбэр дүрсгүй, савныхаа эзлэхүүнээр, жижиг хэсэг нь эмх цэгцгүй, хол байрлаж, байнгын эмх замбараагүй хөдөлгөөнд оршдог гэсэн тодорхойлолт аль бодисыг нь тодорхойлж байна вэ?




- A 1
- B 2
- C 3
- D 1,3

7 Зурагт ямар шинжтэй материалыг илэрхийлсэн байна вэ?



- A зөөлөн
- B тунгалаг
- C уян
- D хэврэг

8 Сурагч цахилгаан дамжуулах хэлхээг зурагт үзүүлсний дагуу угсарчээ. Аль материалыг сонгож X үсгээр тэмдэглэсэн хэсэгт байршуулбал чийдэн асах вэ?



- A шаазан
- B резин
- C зэс утас
- D хуванцар

9 Даавууны ямар шинж чанарт нь үндэслэн ванны өрөөний алчуур хийдэг вэ?

- A нягт их
- B гялтганах
- C ус шингээх
- D уян харимхай

10 Хайруулын таваг хурдан халдаг нь түүний ямар шинж чанартай холбоотой вэ?

- A нягт их
- B гялтганах
- C давтагдах
- D дулаан дамжуулах

11 Ижил хэмжээтэй материалын ус шингээх чанарыг туршсан туршилтын үр дүнг өгөв. Ус шингээх чадварын ихсэх дарааллаар байрлуулаарай.

Материал	Торго	Хөвөн даавуу	Сальфетик	Даавуу
Шингээсэн дуслын тоо	2	5	7	4

- A торго < хөвөн даавуу < даавуу < сальфетик
- B сальфетик < даавуу < хөвөн даавуу < торго
- C торго < даавуу < хөвөн даавуу < сальфетик
- D хөвөн даавуу < торго < сальфетик < даавуу

12 Гараар барихад гулсамттай, исгэлэн шинж чанартай байвал ..... бодис, материал гэнэ.

- A хүчиллэг
- B суурилаг
- C гулсамттай
- D бат бэх

13 Судлаач үл мэдэгдэх өнгөгүй уусмалд фенолфталеины уусмалаас 2-3 дуслыг дусаахад аль уусмалын өнгийг өөрчлөх вэ?

- A сүүний хүчлийн уусмал
- B алимны хүчлийн уусмал
- C нимбэгний хүчлийн уусмал
- D шүдний оо-ны уусмал

14 Шүдний оо-ны уусмал дээр хүрэн байцайны индикатор дусаахад уусмал ямар өнгөтэй болох вэ?

- A ягаан
- B шар
- C ногоон
- D улаан

15 Натрийн гидроксид дээр цууны хүчил бага багаар нэмэх үед уусмалын орчин хэрхэн өөрчлөгдөхийг таамаглана уу.

- A суурилгаас саармаг, хүчиллэг
- B хүчиллэгээс саармаг, суурилаг
- C суурилгаас саармаг, саармаг
- D хүчиллэгээс саармаг, хүчиллэг

16 Тунгаа туршилтын үед гар дээрээ хүчил дусаажээ. Түүний арьс салст нь улайсан байна. Энэ үед Тунгаад өгөх оновчтой зөвлөмж аль нь вэ?

- A гараа угаан хүйтэн зүйлээр жин тавих
- B гараа усаар угааж, содын уусмалаар зайлах
- C гараа усаар угаан сул хүчлийн уусмалаар зайлах
- D гараа усаар угаах

17 Хүчиллэг борооны эх үүсвэрийг олоорой.

- A ус буцлахад гарах уур
- B нуурын ус уурших
- C үйлдвэрийн яндангаас гарах утаа
- D ургамал тарих

18 Гол мөрний усыг бохирдуулагч хүчин зүйлийг сонгоно уу.

- A борооны ус
- B мод
- C агаар
- D хог хаягдал


19 Ихэнх ургамал ургахад таагүй орчинг бүрдүүлэхийн тулд ямар уусмалаар услах вэ?

- A саармаг уусмал
- B хүчиллэг уусмал
- C сул суурилаг уусмал
- D суурилаг уусмал

20 Зурагт ахуй амьдрал дахь усны хэрэглээг харуулсан байна. Аль хэрэглээнд цэвэршүүлсэн ус хэрэглэх нь хамгийн чухал вэ?



1



2



3

- A зөвхөн 1
- B зөвхөн 2
- C зөвхөн 3
- D 1, 2, 3